



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 4/08

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цамхагийн болон бүсийн дадлагажуурын танхимд ашиглах компьютер 22 ширхэг нийлүүлэх ИНЕГ/ЦА/ТББ/Б-23/17 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

С.Батхуяг

Нисэхийн сургалтын төвийн дэд захирал

Гишүүд:

Б.Амарсайхан

Нисэхийн сургалтын төвийн компьютер мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн

Б.Санчир

Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Д.Атарсайхан


Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Шуурхай ажиллагааны тасгийн ахлагч инженер

Х.Наранцацрал

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын шаардлагын дагуу шалгаж хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэн комиссын акт, холбогдох бусад материалын хамт Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлэхийг ажил хүлээж авах Комисс /С.Батхуяг /-т даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН